

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2019

ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБООНЫ ХҮРЭЭНД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН БОЛОМЖ

Э.Бямбажав¹

<i>JEL ангилал:</i> E60, F02, F55 <i>Түлхүүр үг:</i> Евразийн эдийн засгийн холбоо, Монгол Улс, хамтын ажиллагаа, Евразийн эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ	<i>Хураангуй:</i> Энэхүү өгүүлэлд Евразийн эдийн засгийн холбоо, Монгол Улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийг судалж, Евразийн эдийн засгийн холбооны хамтын ажиллагааны Гэрээ, түүний дагалдах 30 гаруй баримт бичгийн ямар дүрэм, журам, хөшүүрэг, хөнгөлөлт нь манай оронд ач холбогдолтой байж болох тухай санал бодлоо илэрхийлсэн байна.
--	--

1. Евразийн эдийн засгийн холбоо ба Монгол Улс

Евразийн эдийн засгийн холбоо байгуулагдаад удаагүй ч үйл ажиллагаа нь идэвхжиж байгааг олон орны хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэлээд тэмдэглэн бичиж байна. Тус холбоонд элсэх сонирхлоо Армен, Киргизстан, Узбекистан, Тажикистан зэрэг улс илэрхийлээд байна. БНХАУ ч Евразийн эдийн засгийн холбоонд эерэгээр хандаж байна гэдэг. Энэ байдлыг Монголын Улсын Засгийн газар анхаарч, Ерөнхий сайд Ч.Сайханбилэг ОХУ-д 2015 оны зургаадугаар сард айлчлах үеэр Евразийн эдийн засгийн комиссын Сайд нарын Зөвлөлийн дарга В.Б.Христенкотой “Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс хоорондын хамтын ажиллагааны тухай Санамж бичиг”-т гарын үсэг зуржээ. Хамтын ажиллагааны эхлэл болж буй Санамж бичигт дурдсанаар: “Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комиссын хамтын ажиллагааны Ажлын хэсэг” байгуулж, улс хооронд тулгарч буй тарифын болон тарифын бус хориг саадыг арилгах, худалдаа, гаалийн дүрэм журмыг хялбарчлах, үр ашигтай, найдвартай, тогтвортой тээврийн чиглэл болон үйлчилгээг бий болгох, худалдааны тэнцвэртэй байдал, чанартай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, түүнчлэн Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбооны гишүүн орнуудын аж ахуйн нэгжийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нөхцөлийг бий болгох чиглэлээр арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөсөн байна. Тэрчлэн тээврийн тариф, гаалийн татварын асуудлыг ОХУ-ын Засгийн газар Евразийн

¹ Судлаач, профессор, Монгол Улсын гавьяат эдийн засагч
Цахим шуудан: ikhtusch@yahoo.com

эдийн засгийн комисст шилжүүлсэн тул энэ комиссын үйл ажиллагаанд Монгол Улс идэвхтэй оролцож, ажиглагч орны хувьд ОХУ-аар дамжин гарч байгаа тээвэр болон гаалийн татвар, бусад асуудалд дэмжлэг авах бодит шаардлага гарч байгааг судлаачид тэмдэглэж байна. Дээрхээс үзэхэд, Евразийн эдийн засгийн холбооны үйл ажиллагаатай манай орны холбогдох байгууллага танилцаж, Евразийн эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Гэрээ, түүний дагалдах 30 гаруй баримт бичгийн заалт, нөхцөл, журмын талаар сайтар мэдлэгтэй болох, энэ холбооны чухам ямар механизм, журам, хөшүүрэг, хөнгөлөлт нь Монгол Улсад ач холбогдолтой байхыг судлан тодорхойлох нь зүйтэй юм.

Холбоо нь гишүүн орнуудын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, Талуудын тэгш эрх, үндэсний эрх ашгийг хүндэтгэх, шударга өрсөлдөөний зарчмыг баримтлах, гишүүн орнуудын эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, гишүүд хоорондын харилцаанд хамгийн таатай нөхцөл боломж бий болгох, гишүүн орнуудтай хамтран, эсвэл бие даан гэрээ хэлцэл байгуулах, олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, шийдвэр гаргахдаа хэлэлцэж байгаа асуудлаар зөвхөн нэгдмэл тохиролцоонд хүрсэн байх нөхцөлийг баримтлах (*хэлэлцэж байгаа асуудлаар аль нэг улс өөр байр суурьтай байгаа бол тухайн асуудлаар шийдвэр гаргахгүй*), аль нэг тал нь давамгайлах, эсвэл хүч түрч асуудал шийдэхгүй байх, холбооны удирдлагад гишүүн улс бүр эрх тэгш, тэнцвэртэй төлөөлөл, ижил оролцоотой байх зэрэг гэрээний заалтууд нь энэ холбооны үйл ажиллагаа нь эдийн засгийн хамтын ажиллагаанд чиглэж, эдийн засгийн шинэ интегралчлалыг хөгжүүлэхийг гол зорилт болгожээ гэдгийг харуулж байна.

Евразийн эдийн засгийн хамтын ажиллагааны тухай гэрээний нэлээд олон заалт нь Монгол Улсын эдийн засгийн сонирхлыг татахаар байна. Үүнд:

Евразийн Гаалийн холбоо нь барааны нэгдсэн ангилал, гаалийн нэгдсэн тарифтай, тарифын хөнгөлөлтийн нэгдсэн системтэй, гишүүн орнуудын хооронд барааг гаалийн мэдүүлэг, улсын хяналт шалгалт (*тээвэр, эрүүл ахуй, мал эмнэлэг, ургамлын хорио цээр*)-гүй чөлөөтэй нэвтрүүлдэг. Гишүүн орнууд хоорондын худалдаанд бараа орох, гарах гаалийн татвар, хураамж, тарифын бус зохицуулалтын арга хэмжээ, тусгай хамгаалалт, демпингийн эсрэг болон нөхөн төлбөрийн арга хэрэгслийг хэрэглэдэггүй зэрэг нь манай орны гадаад худалдаа, ялангуяа, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг эдгээр орнуудад экспортлох нөхцөлийг үлэмж сайжруулах боломж гэж үзэж байна.

Бараа, гүйлгээг нэмэгдүүлэх, эрүүл ахуйн шаардлагыг хангахад эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн худалдааг гишүүн орнууд нэгдмэл дүрэм, журмаар зохицуулж, чанар, аюулгүй байдалд тавих шаардлагыг хангаж байгаа нь манай орны импорт, гадаадаас оруулж ирэх эм, эм бэлдмэлд тавих нөхцөл сайжрахад эерэгээр нөлөөлөх боломжтой. Ариун цэврийн нэгдсэн шаардлагад үл

тохирох бараа, мал, амьтны халдварт өвчин, хүн, малд адилхан халдварлах өвчин үүсгэгч нян холбооны нутаг дэвсгэрт орж ирэх, тархахаас сэргийлэх журмыг хэрэгжүүлснээр гадаад худалдаанд оролцогч, үйлдвэрлэгч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, экспорт, импортын үйл ажиллагаанд оролцогчдын сонирхлыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Гадаад худалдаанд тарифын хөнгөлөлт хэрэглэж, хөгжиж буй орноос импортлох барааны гаалийн татварын хувь хэмжээг 75 хувиар тооцох, буурай хөгжилтэй орны гарал үүсэлтэй барааны орох гаалийн татвар тэг байж, гаалийн тарифын бус зохицуулалт хийдэг бөгөөд жишээлбэл, холбооны нутаг дэвсгэрт үйлдвэрлэдэг (*олборлох, тариалах г.м.*) бараа, бүтээгдэхүүнтэй ижил, төстэй бараа гуравдагч орноос орж ирэх бол квот, хязгаар тогтоодог журам нь манайх шиг жижиг, бас онцлог зах зээлтэй, байгалийн нөхцөл, нөлөөнөөс хамааралтай орны хувьд шуурхай арга хэмжээ авах боломжийг бүрдүүлэх учиртай.

Макро эдийн засгийн нэгдсэн бодлого хэрэгжүүлж, гишүүн орнуудын эдийн засгийн тэнцвэртэй, тогтвортой хөгжлийг хангах, орон тус бүрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр өгөөжтэй хамтын ажиллагааг хөгжүүлж, эдийн засгийн хөгжлийн макро эдийн засгийн үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлохоор заажээ. Үүнд:

- Төсвийн жилийн алдагдал ДНБ-ий 3 хувиас хэтрэхгүй байх;
- Улсын өр ДНБ-ий 50 хувиас ихгүй байх;
- Инфляцийн жилийн түвшин урьдах жилийнхээс дээрх үзүүлэлт хамгийн бага байгаа гишүүн орны инфляцийн түвшнээс 5 нэгж хувиар илүүгүй хэмжээгээр давсан байх зэрэг юм.

Энэ нь эдийн засгийн тодорхой хөгжлийг хангах үзүүлэлт учраас манай орны хувьд ч анхаарч харьцуулах, бодлого боловсруулахад хэрэгтэй юм. Үндэсний валютын ханшийн зохицуулалтыг гишүүн орны төв банк харилцан нэгдсэн журмаар гүйцэтгэх ажээ.

Ийнхүү Евразийн эдийн засгийн холбооны хүрээнд хамтран ажиллах, эдийн засгийн механизм, зохицуулалт, гааль, татвар, гадаад худалдааны бодлого, зохих чөлөөлөлт, хөнгөлөлт зэрэг нь энэ холбооны гишүүн орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарах, ач холбогдолтой нэлээд асуудал, журам нөхцөл, нэгдмэл хандлага байгааг сайтар судалж, чухамхүү ямар хүрээнд Монгол Улсын оролцоо, сонирхол байж болохыг тодорхойлох нь чухал юм.

Евразийн эдийн засгийн хамтын ажиллагааны талаарх гэрээ, түүний хавсралт, протокол, журам, нөхцөлийг сайтар судлах, сонирхогчдод хэрэг болох үүднээс “Евразийн эдийн засгийн хамтын ажиллагааны тухай гэрээ” –ний зарим заалтыг товчлон танилцуулж байна.

2. Евразийн эдийн засгийн холбоо

1. Бүгд Найрамдах Беларусь улс, Бүгд Найрамдах Казахстан улс, ОХУ нь Евразийн эдийн засгийн интеграцийн тухай 2011 оны арваннэгдүгээр сарын 18-ны өдрийн Тунхаглалыг үндэслэн “Евразийн эдийн засгийн холбоо” (Цаашид “Холбоо” гэнэ)-г 2014 оны тавдугаар сарын 30-ны өдөр байгуулжээ. Энэхүү Холбоо нь бүс нутгийн эдийн засгийн интегралчлалын эрхзүйн этгээдийн эрхийг эдэлсэн олон улсын байгууллага юм.

2. Холбооны гол зорилго нь:

- Ард иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд чиглүүлэн гишүүн орнуудын эдийн засгийг тууштай хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх;
- Бараа, үйлчилгээ, хөрөнгө, ажиллах хүчний нэгдсэн зах зээл бий болгох;
- Даяарчлалын нөхцөлд үндэсний эдийн засгийг тал бүрээр хөгжүүлэх, хамтран ажиллах, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх.

3. Холбооны үйл ажиллагааны үндсэн зарчим (*гишүүн орнуудаас гэрээгээр олгосон эрх хэмжээний хүрээнд Холбооны үйл ажиллагааг дор дурдсан зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэх*):

- Гишүүн орнуудын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, гишүүн орнуудын улс төрийн байгууллын онцлогийг хүндэтгэх, Талуудын тэгш эрх, үндэсний эрх ашгийг хүндэтгэх үндсэн дээр олон улсын эрх зүйн хүрээнд хамтран ажиллах;
- Зах зээлийн эдийн засгийн болон шудрага өрсөлдөөний зарчмыг баримтлах, шилжилтийн үе дуусахад Гаалийн холбоо нь аливаа хасалт, хязгаарлалтгүй ажиллах, Холбоо үүрэгт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд нь гишүүн орнууд таатай нөхцөл боломж олгож, Холбооны зорилгоо биелүүлэхэд нь саад тотгор болох арга хэмжээ авахаас зайлсхийх.

4. Энэхүү гэрээ, Холбооны хүрээнд байгуулсан олон улсын гэрээ хэлцлүүд, Холбооноос гуравдагч этгээдтэй байгуулсан олон улсын гэрээ хэлцлүүд нь Холбооны эрхийг бүрдүүлэгч баримт бичиг аж. Холбооны гаргасан шийдвэрийг гишүүн орнууд заавал даган мөрдөнө. Холбооноос гуравдагч этгээдтэй байгуулах гэрээ нь Холбооны үндсэн зорилго, зарчим болон үйл ажиллагааны дүрэмтэй зөрчилдөх ёсгүй.

5. Холбоо нь зорилтоо хэрэгжүүлэхэд чиглүүлэн олон улсын үйл ажиллагааг эрхлэх бөгөөд энэ талаарх журмыг Евразийн эдийн засгийн Дээд зөвлөлийн шийдвэрээр тогтооно. Холбоо нь гадаад орон, олон улсын байгууллага, олон улсын интегралчлалын эвсэл нэгдэлтэй олон улсын үйл ажиллагаа эрхлэн явуулах, бие даан дангаараа, эсвэл гишүүн орнуудтай хамтран олон улсын гэрээ, хэлцэл байгуулах эрхтэй.

6. Холбоо нь дараах байгууллагатай. Үүнд:

- Евразийн эдийн засгийн Дээд зөвлөл (цаашид “Дээд зөвлөл” гэх);
- Евразийн Засгийн газар хоорондын Зөвлөл (цаашид “Засгийн газар хоорондын Зөвлөл” гэх);
- Евразийн эдийн засгийн комисс (цаашид “Комисс” гэх);
- Евразийн эдийн засгийн холбооны шүүх (цаашид “Холбооны шүүх” гэх).

Холбооны дээрх байгууллага нь энэхүү Гэрээ болон Холбооноос байгуулсан олон улсын гэрээгээр олгосон эрх мэдлийн хүрээнд ажиллана.

7. Холбооны Дээд зөвлөл, Засгийн газар хоорондын Зөвлөл, Комиссыг орос цагаан толгойн дарааллаар ээлжлэх зарчмаар нэг гишүүн орон нэг жилийн хугацаагаар, дахин сунгагдах эрхгүйгээр даргална.

8. Холбооны байгууллагад гишүүн орны тухайн салбарын мэргэжлийн боловсрол, ажлын арга туршлагатай иргэн ажиллах эрх эдэлнэ. Тэгэхдээ албан тушаалтнууд дан нэг улсын иргэн байж болохгүй, албан тушаалд горилогчдыг гишүүн орон дэвшүүлж, Талуудын тэгш оролцоотой сонгон шалгаруулах комисс Талуудаас комиссын санхүүжилтэд оруулсан хувь оролцоог харгалзан сонгон шалгаруулдаг.

9. Дээд зөвлөл:

- 9.1. Холбооны эрх барих дээд байгууллага нь Дээд зөвлөл бөгөөд бүрэлдэхүүнд нь гишүүн орнуудын Төрийн тэргүүн ордог. Дээд зөвлөл жилд нэгээс доошгүй удаа хуралдана.
- 9.2. Дээд Зөвлөлийн тэргүүн Зөвлөлийн хурлыг даргалан хуралдуулах бөгөөд Дээд зөвлөлийн үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ.
- 9.3. Дээд зөвлөл нь Холбооны хөгжлийн стратеги, чиг, хэтийн төлөвийг тодорхойлох, Комиссын зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, тэргүүнийг нь томилж эрх мэдлийг тогтоох, Холбооны төсөвт гишүүн орноос оруулах хувь, хураамжийн хэмжээг тогтоох, Холбооны дүрэм, төсөв, түүний биелэлтийг батлах, Холбооны шүүхэд асуулга тавих, Холбоонд гишүүн элсүүлэх, холбооны байгууллагад гадаад аудит хийх журмыг батлах, Засгийн газар хоорондын Зөвлөл, Комисст үүрэг даалгавар өгөх зэрэг Холбооны үйл ажиллагааны асуудлаар шийдвэр гаргана. Ийнхүү шийдвэр нь олонхын саналаар батлах захирамж байна.

10. Засгийн газар хоорондын Зөвлөл:

Холбооны Засгийн газар хоорондын Зөвлөл нь гишүүн орнуудын Засгийн газрын тэргүүнээс бүрдэх бөгөөд жилд хоёроос доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн бүхий л үйл ажиллагаа болон Зөвлөлийн хурлыг Засгийн газар хоорондын Зөвлөлийн тэргүүн удирдан зохион байгуулна.

11. Холбооны комисс:

Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг Комисс зохицуулан эрхэлнэ. Комисс нь Зөвлөл, Коллегиос бүрдэх бөгөөд Холбооны үйл ажиллагаатай холбогдсон шийдвэр захирамж, зөвлөмжийг Коллегийн гишүүдийн олонхын саналаар гаргана. Комиссын статус, зорилт, бүрэлдэхүүн, үүрэг, бүрэн эрх болон ажиллах журмыг Хавсралт 1-д тодорхойлсон. Комисс нь ОХУ-ын Москва хотод байрладаг.

12. Холбооны шүүх:

Холбооны шүүх нь байнгын үйл ажиллагаатай шүүх бөгөөд Беларусь улсын Минск хотод байрладаг.

13. Холбооны төсөв:

Холбооны байгууллага нь Холбооны төсвийн тухай дүрэмд зааснаар гишүүн орноос Холбооны төсөвт оруулах гишүүнчлэлийн хураамжаар (рубль) санхүүждэг.

14. Холбооны төсвийн бүрдүүлэлт, удирдлага, зарцуулалт, эд хөрөнгийн ашиглалтын байдалд гишүүн орнуудын санхүүгийн хяналтын төрийн дээд байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн байцаагчдын хэсэг Гадаад аудит (хяналт) хийж, дүнг Дээд зөвлөл хэлэлцэнэ.

15. Гаалийн холбоо:

15.1. Мэдээлэл харилцааны хамтын ажиллагаа:

Холбооны хүрээнд мэдээлэл, харилцааны хамтын ажиллагааг хэрэгжүүлж, Холбооны интегралчлалын үйл ажиллагаа, явцыг холбооны нэгдсэн мэдээллийн системээр хангана. Гишүүн орнуудын төрийн мэдээллийн сангууд болон мэдээллийн системийн үр дүнтэй хамтын ажиллагааг хангах, зохицуулах чиглэлээр мэдээллийн харилцан зөвшилцсөн бодлого явуулна.

15.2. Холбоонь албан ёсны статистик мэдээллийг бүрдүүлэх үйл ажиллагааг нэгдсэн журмаар зохицуулан явуулдаг. Энэхүү журмыг гэрээний хавсралт Протоколоор тогтоосон ба статистикийн үзүүлэлт, хугацаа, гаргах маягт, загвар, аргачлалыг Комиссоос баталдаг. Статистикийн албан ёсны мэдээллийг гишүүн орны статистикийн төв байгууллага гаргаж, Холбоонд тогтоосон хугацаанд өгдөг. Энэхүү мэдээлэл нь тухайн улс орны “улсын нууц” үзүүлэлтэд хамаарахгүй. Холбоо нь статистик мэдээллийг Холбооны цахим хуудсанд байршуулна.

15.3. Гаалийн холбоо нь гаалийн нэгдсэн тарифтай байх ба гишүүн орнуудын нутаг дэвсгэрийн хооронд барааг гаалийн мэдүүлэг, улсын хяналт шалгалт (*тээвэр, эрүүл ахуй, малын эрүүл ахуй, ургамлын хорио цээр*)-гүй чөлөөтэй тээвэрлэдэг.

Гуравдагч талтай харилцах харилцаанд бараа худалдааны нэгдсэн тариф үйлчилдэг. Гаалийн нэгдсэн тариф нь гуравдагч орноос Холбооны нутаг дэвсгэрт орж ирэх бараанд ногдуулах гаалийн татварын хувь хэмжээг тогтоосон жагсаалт байдаг.

Холбооны худалдааны чөлөөт бүс бүрдүүлж буй орноос гаралтай бараа, Холбооны тарифын хөнгөлөлтийн нэгдсэн системийн хэрэглэгч буурай хөгжилтэй орноос гаралтай бараа зэрэгт гаалийн татварын хувь хэмжээг бууруулж, Гаалийн тарифын хөнгөлөлт (*преференци*) хэрэглэдэг.

15.4. Гишүүн орнуудын хөгжилд тус дэм болох хөрөнгө оруулалт татах, шинэ технологид суурилсан үйлдвэрлэл хөгжүүлэх, тээврийн дэд бүтэц, аялал жуулчлал, амралт сувиллын салбарыг хөгжүүлэхэд чиглүүлэн эдийн засгийн чөлөөт (*тусгай, оницгой*) бүс болон чөлөөт агуулах байгуулан ажиллуулдаг

15.5. Холбооны гишүүн орнууд хоорондын худалдаанд орох болон гарах гаалийн татвар (*хураамж, татвар, шимтгэл*), тарифын бус зохицуулалтын арга хэмжээ, тусгай хамгаалалт, демпингийн эсрэг болон нөхөн төлбөрийн арга хэрэгслийг хэрэглэдэггүй.

15.6. Хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн ёс суртахуун, хууль ёсыг сахин хамгаалах, хүрээлэн буй орчин, амьтан, ургамал, соёлын үнэт зүйлийг хамгаалах, олон улсын үүргээ биелүүлэх, улсыг батлан хамгаалах, гишүүн орны аюулгүй байдлыг хангах шаардлага гарсан тохиолдолд Холбооны гишүүн орнуудын хоорондын худалдаанд хязгаарлалт хэрэглэх эрхтэй. Дээрх шаардлагын үүднээс зарим төрлийн барааны эргэлтийг хязгаарлаж болно.

16. Эмийн бэлдмэлийн нэгдсэн зах зээл буй болгох:

Энэхүү Холбооны гэрээгээр эм бэлдмэл болон эмнэлгийн хэрэгсэлийн худалдааг гишүүн орнууд нэгдсэн журмаар зохицуулдаг. Эм бэлдмэлийн нэгдсэн зах зээлийг дараах зарчимд нийцүүлэн буй болгохоор заажээ. Үүнд:

- Гишүүн орнуудын эм бэлдмэлийн худалдааны зах зээлийн талаарх хууль тогтоомжийг харилцан уялдаатай болгон төгөлдөржүүлэх;
- Холбооны нутаг дэвсгэр дээр эргэлтэд орж буй эм бэлдмэлийн чанар, үр нөлөө, аюулгүй байдалд тавих шаардлагын нэгдмэл байдлыг хангах;
- Эм борлуулалтын нэгдсэн дүрэм журамтай болох;
- Эм бэлдмэлийн худалдаанд тавих хяналтын талаар хууль тогтоомжийг улам төрөлжүүлэн зохицуулах.

•

Эм бэлдмэлийн нэгдсэн зах зээлийн үйл ажиллагааг Холбооны хүрээнд 2015 оны нэгдүгээр сарын 1 хүртэлх хугацаанд байгуулах олон улсын гэрээний дагуу 2016 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж байна.

17. Холбооны гаалийн зохицуулалт:

Энэхүү гэрээ болон Гаалийн журам, гаалийн эрх зүйн харилцааг зохицуулсан олон улсын гэрээ хэлцэл, актуудын дагуу нэгдсэн гаалийн зохицуулалтыг хэрэгжүүлдэг.

17.1. Гадаад худалдааны бодлого. Холбоо нь гадаад худалдааны бодлогоо дараах үндсэн зарчмыг баримтлан хөгжүүлнэ. Үүнд:

- Гишүүн орнуудын гадаад худалдаанд оролцогчийн хувьд аль болох хүндрэлтэй бус арга хэрэгсэл, механизмыг хэрэглэх;
- Гадаад худалдааны арга хэрэгсэл, механизм нь ил тод, шударга байх;
- Худалдаанд оролцогч, үйлдвэрлэгч, бараа, үйлчилгээ хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- Гадаад худалдаанд оролцогчийн эрхийг хүндэтгэх.

17.2. Дээд зэргээр таатай дэглэм байх. Гишүүн орнуудын олон улсын гэрээ, Холбооноос гуравдагч талтай байгуулсан гэрээнд заасан тохиолдолд Тариф болон худалдааны тухай 1994 оны ерөнхий гэрээний дагуу гадаад худалдааны дээд зэргийн таатай нөхцөлийг хэрэглэдэг.

17.3. Чөлөөт худалдааны горим дэглэмийн хувьд 1994 оны ГАТТ-ын заалтыг баримтлах бөгөөд 2015 оны нэгдүгээр сарын 1-ээс өмнө байгуулсан олон улсын гэрээгээр гишүүн орнуудад гадаад худалдаанд хөнгөлөлт үзүүлэхээр тохирсон бол түүнийгээ мөрдөх эрхтэй.

17.4. Холбоо нь хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнуудаас гарал үүсэлтэй бараа бүтээгдэхүүнд тарифын хөнгөлөлт үзүүлнэ. Хөгжиж буй орнуудаас орох барааны гаалийн татварын хувь хэмжээг 75 хувиар тооцож хэрэглэнэ. Харин буурай хөгжилтэй орнуудаас гарал үүсэл бүхий хөнгөлөлттэй барааны хувьд орох гаалийн татварыг “тэг” хувиар тооцож хэрэглэнэ.

17.5. Холбооны гаалийн нутаг дэвсгэрт оруулан ирж буй барааны гарал үүслийг тодорхойлох нэгдсэн дүрэмтэй байх бөгөөд хөгжиж буй болон буурай хөгжилтэй орноос оруулж ирж буй бараа, чөлөөт худалдааны дэглэм хэрэглэж буй улс орноос оруулж ирэх тарифын хөнгөлөлт үзүүлэх барааны гарал үүсэл тодорхойлох дүрмийг мөн хэрэглэнэ.

17.6. Гуравдагч талын зүгээс барааны гарал үүсэл тодорхойлох асуудлаар удаа дараа зөрчил гаргасан тохиолдолд тухайн орноос оруулах барааны гарал үүслийн тодорхойлолт зөв хийгдсэн эсэхэд холбооны гишүүн орнуудын гаалийн байгууллагаар шалгалт хийлгэх шийдвэрийг

Комиссоос гаргаж болохоос гадна ийм зөрчил удаа дараа давтагдвал тухайн орны барааны гарал үүслийн бичиг баримтыг хүлээн авахыг түр зогсоох шийдвэрийг Комиссоос гишүүн орны гаалийн байгууллагад өгч болно.

17.7. Холбооны гуравдагч талтай хийх худалдааны аливаа хязгаарлалтад мониторинг хийж, түүнийгээ арилгах арга хэмжээ авах бөгөөд улс хоорондын худалдаанд маргаан үүсэх тохиолдолд гуравдагч талтай зөвлөгөө хийдэг. Холбоо нь гуравдагч талтай хийх худалдаанд гаалийн татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх, тоо хэмжээнд хязгаар тогтоох, хөнгөлөлт үзүүлэхийг түр зогсоох, тухайн улстай хийх худалдааны үр дүнд нөлөөлөх өөр бусад хариу арга хэмжээ авах шийдвэрийг Комисс гаргана.

17.8. Холбоо нь гишүүн орнуудын барааны экспортыг хөгжүүлэх талаар хамтарсан арга хэмжээг гуравдагч талын зах зээлд хэрэгжүүлнэ. Энэ нь экспортын даатгал, зээлжилт, олон улсын лизинг, “Евразийн эдийн засгийн холбооны бараа, бүтээгдэхүүн” гэдэг ойлголтыг нэвтрүүлэх, үзэсгэлэн яармаг, үзэсгэлэн худалдааны үйл ажиллагаа, сурталчилгаа зэрэг хилийн чанад дахь олон арга хэмжээг багтаадаг.

18. Гаалийн тарифын ба тарифын бус зохицуулалт:

18.1. Холбооны гаалийн нутаг дэвсгэрт Гадаад худалдааны барааны нэгдсэн ангилал, Гаалийн нэгдсэн тариф хэрэглэнэ. Гаалийн орох татвар дараах хувь хэмжээтэй:

- Тарифын хувь хэмжээ нэгдсэн байх ба хил гаалиар бараа тээвэрлэж буй хувь хүн, арилжааны хэлбэр, бусад нөхцөлөөс хамаарч өөрчлөгдөхгүй;
- Тарифын хувь хэмжээг барааны гаалийн үнийн дүн, барааны шинж чанар (*тоо ширхэг, жин, эзлэхүүн г.м.*)-аас хамааруулан тогтоодгоос гадна дээрх хоёр үзүүлэлтийг хосолсон тариф байна;
- Үйл ажиллагааг шуурхай зохицуулах, улирлын чанартай, тэгэхдээ жилдээ 6 сараас хэтрэхгүй хугацаанд үйлчлэх тариф байж болно;
- Холбоонд нэгдэн орсон улс нь Гаалийн нэгдсэн тарифаас өөрөөр тогтоосон тарифаа хэрэглэж болох бөгөөд нэгдсэн тарифаас доогуур тогтоосон гаалийн татвараа зөвхөн өөрийн нутаг дэвсгэрт хэрэглэдэг.

18.2. Гаалийн барааны орох хураамжийн хувь хэмжээнд хөнгөлөлт үзүүлдэг бөгөөд энэ нь төлбөрөөс чөлөөлөх, хувь хэмжээг бууруулах хэлбэрээр тогтоогддог. Тэгэхдээ тарифын хөнгөлөлт нь хувь шинж чанартай байж болохгүй, барааны аль улсаас гаралтайгаас хамаарахгүй.

18.3. Холбооны нутаг дэвсгэрт үйлдвэрлэдэг (*олборлох, тариалах г.м.*) бараатай ижил төстэй бараа гуравдагч орноос орж ирвэл тарифын квот хязгаар тогтоож болно.

19. Холбоо нь гуравдагч орнуудтай хийх худалдаанд тарифын бус зохицуулалтын “*барааг оруулах, гаргахыг хориглох, барааны тоо хэмжээг нь хязгаарлах, экспорт, импортын онцгой эрх тогтоох, тусгай зөвшөөрөл олгох, оруулах, гаргах зөвшөөрлийн журам тогтоох*” зэрэг арга хэрэгслийг хэрэглэнэ. Ийнхүү тарифын бус зохицуулалтын арга хэмжээ нь ил тод, ялгаваргүй байх зарчимд үндэслэдэг.

Худалдааны тарифын бус зохицуулалтыг нэг тал (*гишүүн орон*) дангаар авч хэрэгжүүлж болдог.

20. Холбооны нутаг дэвсгэрт оруулах гуравдагч орны барааны хувьд дотоодын зах зээлийг хамгаалах арга хэмжээг тусгай хамгаалалтын, демпингийн эсрэг, нөхөн төлбөрийн арга хэрэгслийн замаар болон эдгээрээс ялгаатай, хоёр талын арга хэлбэрээр Комиссын шийдвэрээр авч хэрэгжүүлдэг.

Эдгээр арга хэмжээг гуравдагч орны барааг холбооны гаалийн нутаг дэвсгэрт оруулах нь гишүүн орнуудад материалын хохирол учруулж байгаа, хохирол учруулах занал бий болгож байгаа, эсвэл гишүүн орнуудын эдийн засгийн хөгжил (*нийт үйлдвэрлэлийн, эсвэл ижил буюу төстэй, эсвэл шууд өрсөлдөх барааны 25-аас доошгүй хувийг эзэлж буй бараа*)-ийг удаашруулах, саад учруулах нь тогтоогдсон үед хэрэглэнэ.

21. Холбоо нь техникийн зохицуулалтыг дараах зарчмыг баримтлан явуулна.

- Бүтээгдэхүүнд заавал тавих шаардлага, түүний дотор Холбооны нэгдсэн жагсаалтад багтсан бараа, бүтээгдэхүүнд тавих үндэсний шаардлагыг хуульчлан тогтоож байх;
- Холбооны техникийн дүрэм журмыг гишүүн орнуудад нэмэлт, хасалтгүйгээр хэрэглэж, биелүүлж байх;
- Гишүүн орнуудын магадлан итгэмжлэгдсэн хяналт шалгалтын байгууллага нь үйлдвэрлэгч, борлуулагч, худалдан авагч болон хэрэглэгчээс хараат бус байх;
- Худалдаа, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахад хэт их саад хориг тогтоохгүй байх;
- Холбооны хүрээнд хэмжилтийн нэгдмэл байдлыг хангах, улс хоорондын стандартыг олон улсын болон бүс нутгийн стандарттай тохируулан төгөлдөржүүлэх;
- Холбооны техникийн дүрмийн шаардлагад тохирсон барааны эргэлтийг Холбооны техникийн дүрэмд зааснаас өөр нэмэлт шаардлага тавилгүйгээр эргэлтэд оруулах;
- Гуравдагч орнуудтай хийх худалдаан дахь техникийн саадыг арилгах

журам, нөхцөлийг Холбооны хүрээнд байгуулсан олон улсын гэрээгээр тодорхойлох.

22. *Ариун цэвэр, малын эрүүл ахуй болон ургамлын хорио цээрийн арга хэмжээ:*

22.1. Эрүүл ахуй, малын эрүүл ахуй болон ургамлын хорио цээрийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх үндсэн зарчим нь зөвхөн хүн, амьтан болон ургамлын амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэж, олон улсын болон бүс нутгийн стандарт, заавар, зөвлөмжид суурилсан байна. Гишүүн орон тус бүр түр хугацаанд эрүүл ахуй, малын эрүүл ахуй болон ургамлын хорио цээрийн арга хэмжээг Комиссоос баталсан гишүүн орнуудын эрх бүхий байгууллагын харилцан ажиллагааны журмыг үндэслэн авч хэрэгжүүлэх эрхтэй байна.

22.2. Мал, амьтны ариун цэврийн хяналтад хамруулбал зохих бараа, объектод Комиссын баталсан нэгдсэн жагсаалтын дагуу Комиссоос баталсан мал эмнэлгийн нэгдсэн шаардлага тавигдана. Мал эмнэлэг, ариун цэврийн нэгдсэн шаардлагад үл тохирох бараа, мал, амьтны халдварт өвчин, үүний дотор хүн, малд адилхан халдварлах өвчин үүсгэгч орж ирэх болон тархахаас сэргийлэх чиглэлээр мал эмнэлгийн хяналтад хамруулна. Онцгой аюултай, хорио цээртэй бөгөөд мал, амьтнаас хүнд халдварладаг өвчний голомтоос урьдчилан сэргийлэх, оношлох, тархаахгүй байх, устгах талаар хамтын ажиллагааг Комиссоос тогтоосон журмын дагуу хэрэгжүүлнэ. Тухайн нутаг дэвсгэрт орж ирэх гишүүн улсын бараа нь мал эмнэлгийн байгууллагаас олгосон зөвшөөрөл, мал эмнэлгийн гэрчилгээ байгаа нөхцөлд Холбооны гаалийн нутаг дэвсгэрт нэвтэрнэ. Гишүүн орнууд нь халдварт өвчний тархалтын нөхцөл байдал гуравдагч болон гишүүн орнуудад хүндэрсэн мэдээлэл авсан тохиолдолд түр хугацаанд мал эмнэлгийн шаардлага, түүний дотор мал эмнэлэг, ариун цэврийн хойшлуулшгүй арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх эрхтэй.

22.3. Ургамлын хорио цээрийн арга хэмжээг Холбооны гаалийн хил дээр, Гаалийн нутаг дэвсгэрт Комиссоос баталсан хорио цээрийн барааны жагсаалтад орсон бүтээгдэхүүн, Холбооны хорио цээрийн объектын нэгдсэн жагсаалтад багтсан объект, мөн хорио цээрийн объектод хэрэгжүүлнэ.

23. *Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах:*

Хэрэглэгч, гишүүн орнуудын иргэдийн эрх ашиг, тэдгээрийн хамгаалалт нь нэгдмэл бодлогоор адил тэгш нөхцөлийг бүрдүүлэхэд суурилагдаж, гишүүн орнуудын нутаг дэвсгэрт хамгаалагдана.

24. Макро эдийн засгийн бодлого:

Гишүүн орнуудын эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангах макро эдийн засгийн нэгдмэл бодлого нь дараах чиглэлээр хэрэгжинэ.

- 24.1. Холбооны интегралчлалын нөөц бололцоо, гишүүн орон тус бүрийн өрсөлдөх чадварыг ашиглан эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах.
- 24.2. Эдийн засгийн үйл ажиллагааны нэгдмэл зарчмыг бий болгож, үр өгөөжтэй хамтын ажиллагааг хангах.
- 24.3. Дотоод эдийн засгийн тогтвортой байдал, гадны нөлөөнд тэсвэрлэх чадварыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.
- 24.4. Гишүүн орнуудын нийгэм-эдийн засгийн хөгжлийг дүгнэх нэгдмэл зарчим, чиг баримжаа үзүүлэлтийг боловсруулж гаргах.
- 24.5. Гишүүн орнуудын эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг дараах макро эдийн засгийн үзүүлэлтийг тоон илэрхийллээр тодорхойлж, эдийн засгийн бодлогоо боловсруулдаг:
 - Нэгдсэн төсвийн жилийн алдагдал нь дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувиас хэтрэхгүй байх;
 - Улсын өр ДНБ-ий 50 хувиас хэтрэхгүй байх;
 - Инфляцийн жилийн түвшин урьдах жилээс дээрх үзүүлэлт хамгийн бага байгаа гишүүн орны инфляцийн түвшингээс 5 нэгж хувиар илүүгүй хэмжээгээр давсан байх.

25. Валютын бодлого:

Эдийн засгийн интегралчлалыг гүнзгийрүүлэх, валют, санхүүгийн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх, гишүүн орнуудын нутаг дээр бараа, үйлчилгээ, капиталын чөлөөтэй хөдөлгөөнийг хангах, үндэсний валютын үүргийг дээшлүүлэх, гишүүн орны валютын харилцан хөрвөх зорилтыг хангахад чиглүүлэн дараах зарчимд үндэслэсэн валютын нэгдмэл бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ:

- Интегралчлалын макро эдийн засгийн нөхцөл байдалд тохирсон валютын бодлого явуулах, орнуудын хандлага, аргыг шат дараалалтайгаар ойртуулах;
- Валютын салбар дахь интегралчлалын үйл явцыг хөгжүүлж, үндэсний болон улс хоорондын зохион байгуулалт, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх;
- Интегралчлалын үйл явцад сөргөөр нөлөөлж болзошгүй ажиллагааг валютын салбарт үл хэрэглэх;

- Үндэсний валютад итгэх итгэлийг гишүүн орнуудын дотоод зах зээл болон олон улсын валютын зах зээлд дээшлүүлэх бодлого явуулах;
- Ханшийн бодлогын зохицуулалтыг гишүүн орнуудын төв банкны удирдлага бүрэлдэхүүнд нь багтсан тусгай байгууллага хэрэгжүүлэх.

26. Үйлчилгээ, худалдаа, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт:

Худалдаа, үйлчилгээний байгууллага, үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын бодлогыг Холбооны хүрээнд чөлөөтэй болгох, түүний эрх зүйн үндсийг хангах үйл ажиллагааг зохицуулалтын зорилго, зүйл, хэрэглэх хүрээг тодорхойлсон гэрээний үндсэн дээр холбогдох нөхцөлийн дагуу хангана.

26.1. Худалдаа, үйлчилгээний байгууллага, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг Холбооны хүрээнд либералчлахдаа гишүүн орны иргэдэд ялгаварлан хандахгүйгээр чөлөөт байдлын нэгдсэн зах зээлийг аль болох олон салбарт бий болгон, дараах зарчмыг удирдлага болгон либералчлана:

- Үйлчлүүлэгч, нийлүүлэгч, хэрэгжүүлэгч, хөрөнгө оруулагчид дотоод зохицуулалт, зөвшөөрлийн шаардлагыг олон улсын шилдэг практикийг харгалзан шат дараатай хялбаршуулах, арилгах замаар дотоодын зохицуулалтыг оновчтой болгох;
- Гишүүн орнуудын хууль тогтоомж, удирдлагын хамтын ажиллагааг төгөлдөржүүлэхдээ тэнцвэртэй харьцааг баримтлах;
- Үйлчилгээ, худалдааны байгууллага, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг либералчлахдаа орон бүрийн харилцан үр ашигтай байдлыг хангах;
- Гишүүн орнуудын хамтын ажиллагааны нөхцөлийг дордуулахгүй байх, улс тус бүрийн үндэсний жагсаалтад заасан хязгаарлалт, хасалт, нэмэлт шаардлага, нөхцөлийг цөөлөх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх;
- Нэгдмэл зах зээл бий болгох хүрээнд үйлчилгээ, худалдааны либералчлалыг Холбооны зах зээлд хамгийн ихээр нөлөөлж буй үйлчилгээний салбарт давуу эрхтэйгээр хэрэгжүүлж, эдийн засгийн үр ашгийг хангах зэрэг юм.

х х х

Цаашид энэхүү гэрээний “Санхүүгийн зах зээлийн зохицуулалт”, “Татвар, татвар ногдуулалт”, “Өрсөлдөөний ерөнхий зарчим, дүрэм”, “Зүй ёсны монополь”, “Эрчим хүч”, “Тээвэр”, “Улсын (*орон нутгийн*) худалдан авалт”, “Оюуны өмч”, “Аж үйлдвэр”, “Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн цогцолбор”, “Хөдөлмөрийн цагаачлал” зэрэгт заасан дүрэм, журам, тогтолцоо, арга хэрэгсэл зэргийг цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна.